

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХЭД “ГУРАВДАХЬ ХӨРШИЙН” ҮҮРЭГ, ХОЛБОГДОЛ

*Л.Оюунгэрэл**

Шинэ мянганд дэлхийн улс орнууд даяарчлал, ялангуяа эдийн засгийн даяарчиллын хүчтэй нөлөөн дор хөгжих болов. Монгол шиг жижиг буурай, хүн ам цөөтэй, газар зүйн хувьд дэлхийн хоёр их гүрнээр хүрээлүүлсэн улс орны хувьд даяарчиллын нөхцөлд эдийн засгийн аюулгүй байдлын асуудалдаа шинэлэг байдлаар хандах шаардлагатай болж байна.

“Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 5 дугаар бүлэгт эдийн засгийн аюулгүй байдлыг тодорхойлохдоо: “Эдийн засгийн аюулгүй байдал гэж дотоод нөөц бололцоогоо ашиглан нөхөн үйлдвэрлэл явуулах, ард түмнийхээ хэрэгцээг хангах, тусгаар тогтносон байдлаа бэхжүүлэх эдийн засгийн чадавхитай байх, шаардлагатай нөхцөлд улс орноо тодорхой хугацаагаар тэтгэж чадах эдийн засгийн бүтэц бүрдсэн байх явдал” гэжээ.

Олон улсын хамтын нийгэмлэгт хүлээн зөвшөөрөгдсөн томъёоллоор бол эдийн засгийн аюулгүй байдлыг “эдийн засгийн эмзэг байдал” гэсэн ойлголтоор илэрхийлж тооцоолж байна. “Эмзэг байдал нь сөргөөр нөлөөлөхүйц цочролд өртөх эрсдэл” гэж тодорхойлжээ. Эмзэг байдлын ерөнхий тодорхойлолтын хүрээнд эдийн засгийн эмзэг байдлыг “эдийн засгийн орчин эрс өөрчлөгдөхөд тухайн орны сөрөг нөлөөлөлд өртөх эрсдэл”¹ гэж тодорхойлж байна.

1999-2001 онд НҮБ-ын нарийн бичгийн дарга нарын газраас тооцож үзсэнээр Монгол Улсын ЭЗЭБИ /эдийн засгийн эмзэг байдлын индекс/ 48.1 буюу дэлхийн нэн буурай хөгжилтэй 64 улсын дотроос 19-т оржээ.² Эдийн засгийн эмзэг байдлыг экспортын барааны төвлөрөл, экспортын орлогын тогтворгүй байдал, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний тогтвортой байдал, аж үйлдвэрийн ба үйлчилгээний салбарын ДНБ-д эзлэх хувь хэмжээ, хүн амын тоо зэргийн дунджаар тооцдог байна.

Монголын хувьд эдийн засгийн эмзэг байдал нь гадаад хүчин зүйлээс ихээхэн хамааралтай байна. Юуны өмнө цөөн тооны экспортын бүтээгдэхүүний (алт, зэсийн баяжмал) дэлхийн зах зээл дээрх үнийн хэлбэлзэл, импортын гол бүтээгдэхүүний нийлүүлэлт нь (эрчим

* Л.Оюунгэрэл - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

хүч, шатахуун) хойд хөршөөс, экспортын гол бүтээгдэхүүн – зэсийн баяжмал, мал аж ахуйн гаралтай түүхий эдийн худалдаа урьд хөршийн зах зээлийн үнэ, гадаад худалдааны бодлогоос шууд хамааралтай байна.

Хоёр хөрштэй тогтоосон худалдаа, хөрөнгө оруулалтын харилцаа нь нэг талаас Монголын эдийн засгийн өсөлтийг хангах, хүн амын амьжиргааг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой байгаа ч нөгөө талаас эдийн засгийн хувьд хоёр хөршөөсөө, ялангуяа өмнөд хөршөөсөө хамаарах эдийн засгийн хамаарал улам бүр өсөх хандлагатай байна. Энэ үйл явц бодит шинж чанартай бөгөөд гол нь Монгол Улсын буурай хөгжилтэй холбоотой юм.

1995-2004 онд гадаад худалдааны талаар хоёр хөрштэй харилцаж ирсэнийг хүснэгтээр харуулвал:

Улс	1995	1999	2000	2001	2002	2003	2004
Нийт бараа эргэлтэнд ОХУ-ын эзлэх хувь	31,1%	20,5%	23,2%	25,7%	23,1%	21,6%	19,0%
Үүнээс Экспорт	13,2%	13,4%	9,6%	10,1%	9,2%	6,2%	2,1%
Импорт	50,1%	29,2%	33,5%	37,7%	34,4%	32,6%	33,3%

Улс	1995	1999	2000	2001	2002	2003	2004
Нийт бараа эргэлтэнд БНХАУ-ын эзлэх хувь	15,7%	29,5%	34,8%	30,3%	29,4%	31,6%	35,5%
Үүнээс Экспорт	15,5%	45,8%	51,2%	44,5%	41,5%	46,1%	47,8%
Импорт	15,9%	15,1%	20,5%	18,8%	20,2%	21,8%	25,1%

Сүүлийн таван жилийн дүнгээр Монголын экспортын 45-50-иад хувь БНХАУ-д, импортын 33% нь ОХУ-д ногдож байна.

ОХУ нь Монголд оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээгээрээ 6 дугаарт /45,8 сая ам.доллар/, компанийн тоогоороо 3 дугаарт /502/ орж байна. ОХУ-аас уул уурхай /17 сая ам.доллар/, барилга байгууламж, барилгын материалын үйлдвэрлэл /5.3 сая ам.доллар/, банк, санхүү /4.1 сая ам.доллар/, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл /4.1 сая ам.доллар/-ийн салбарууд түлхүү хөрөнгө оруулалт хийжээ.³

БНХАУ нь Монгол Улсад оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээгээрээ эхний байранд яваа бөгөөд геологи, уул уурхайн судалгаа, эрэл, хайгуул, олборлолт /360 сая ам.доллар/, худалдаа, нийтийн хоол /151 сая ам.доллар/, инженерийн барилга, байгууламж, барилгын материалын үйлдвэрлэл /29 сая ам.доллар/, хөнгөн үйлдвэрт /23 сая ам.доллар/-ын хөрөнгө оруулалт хийжээ. 2006 оны байдлаар Монголд Хятадын хөрөнгө оруулалттай 2177 компани бүртгүүлжээ.⁴

ОХУ, БНХАУ-тай тогтоосон худалдааны харилцаандаа Монгол Улс цаашид ч түүхий эд экспортлогч ба импортлогч хэвээр байх төлөвтэй байна. Өнөөдөр Монголын экспортын гол бүтээгдэхүүн – зэс, алт, төмрийн хүдэр, ноос, ноолуур, мал аж ахуйн гаралтай бусад түүхий эдийн дийлэнх хувийг урд хөрш рүү гаргаж байна. БНХАУ нь дэлхийн эрчим хүчний хоёр дахь том хэрэглэгч бөгөөд 2020 он гэхэд эрчим хүчний хэрэглээ нь хоёр дахин нэмэгдэх ажээ. 2000 оны байдлаар эрчим хүчний хэрэглээний 60 хувь нь нүүрс байсан бол цаашид байгаль орчин бохирдуулдаггүй сэргээгдэх эрчим хүч, нефть зэрэг чанартай эрчим хүч хэрэглэхээр чармайх болжээ.⁵

Монгол Улс эдийн засгийн эмзэг байдлаа бууруулах шилдэг арга бол экспортын бүтцэд эрс өөрчлөлт хийж, түүхий эд нийлүүлэхэс гадна орчин үеийн техник, технологид суурилсан мал аж ахуйн гаралтай экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх явдал юм. НҮБ-ын аж үйлдвэрийн Хөгжлийн байгууллагаас хийсэн судалгааны үндсэн дээр Монголын цөөн нэр төрлийн экспортын бүтээгдэхүүн, тухайлбал алт /технологид суурилсан бүтээгдэхүүний жагсаалтанд ордоггүй/, арьс шир, амьтны гаралтай бүтээгдэхүүн, оёмол, сүлжмэл бүтээгдэхүүн, нефтийн бүтээгдэхүүн, нүүрс, түүхий нефть, зэс зэргийг дэлхийн зах зээл дээр өрсөлдөх боломжтой бүтээгдэхүүнд оруулжээ.⁶ Ганцхан жишээ дурьдахад дэлхийн боловсруулсан арьс ширний жилийн хэрэгцээ 70 орчим сая ширхэг байдаг бөгөөд үүний 10 хувийг Монгол хангах бүрэн боломжтой байна. Тэгвэл 2005 онд нийт 275.3 мянган ширхэг арьс шир экспортолж 4.1 сая ам.долларын борлуулалт хийсэн нь боломжийнхоо дөнгөж 4.2 хувийг ашигласан байна.⁷ Монгол Улс хөдөө аж ахуйн түүхийн эдийг боловсруулах үйлдвэр байгуулах дотоод

нөөц, бололцооны хувьд ч харьцангуй боловсролтой хүн амтайн ч хувьд боломжоо бүрэн дүүрэн ашиглаж чадахгүй байна. Саяхан Дэлхийн Банкнаас дэлхийн улс орнуудын “мэдлэгт суурилсан эдийн засгийн индексийг” тодорхойлсон ба үүнд Монгол Улс Хятад, Индонезийн өмнө, Төв Азийн улсуудаас Казахстаны дараа хоёрт буюу харьцангуй өндөр үзүүлэлттэй гарчээ.⁸

Өөрөөр хэлбэл түүхий эд, харьцангуй боловсролтой хүн ам бэлэн байгаа бөгөөд гол нь санхүүгийн эх үүсвэр, мөн улс төрийн зохих түвшний шийдвэр гаргаж хэрэгжүүлэх ажил дутагдаж байна. Уул уурхайн баялагт найдаж амьдрахаа больж мал аж ахуйн гаралтай түүхий эдэд суурилсан аж үйлдвэржилтийг урт хугацааны зорилт болгон хэрэгжүүлсэнээр эдийн засгийн эмзэг байдлаа тодорхой түвшинд бууруулах боломжтой юм. Мах, ноос, ноолуур, мал эмнэлгийн салбарт тодорхой хөтөлбөрүүд хэрэгжиж байгаа боловч тэдгээрийг гагцхүү салбарын яамны зорилт болгон тавьж санхүүгийн эх үүсвэрийг улсын ба хувийн салбарын аль алины оролцоотой зохион байгуулж чадахгүй байна. Монголын хувийн хэвшил, банк, санхүүгийн тогтолцоо нь улс үндэсний хэмжээний том зорилтыг шийдвэрлэхэд төрийн бодлогын түвшинд хамтран ажиллаж чадахгүй байна. Цаашдаа уул уурхайн гаралтай түүхий эдийг дулдуйдан амьдрах нь улс орны эдийн засгийн эмзэг байдлыг огт шийдвэрлэхгүй орхиж байгаатай адил юм.

Монгол Улсын эдийн засгийн эмзэг байдлыг бууруулахад чиглэсэн цогц бодлогод доорх чиглэлүүд чухал ач холбогдолтой юм:

1. Алт, зэсийн үнийн хэлбэлзлийг сайтар судалж эрс буурах нөхцөлд аюулгүй байдлын бодлого боловсруулж хэрэгжүүлэх. Дэлхийн зах зээл дээр алт, зэсийн үнэ өндөр байгаа үед хөгжлийн сан байгуулж ажилуулах, хөгжлийн санг хэрхэн юунд зарцуулах тухай хууль боловсруулж хэрэгжүүлж болно. Хөгжлийн сангийн үлэмж хэсгийг мал аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах орчин үеийн үйлдвэр байгуулах томоохон төсөл хэрэгжүүлэхэд зориулах хэрэгтэй байна.

2. Нэг хөршөөс эдийн засгийн хувьд хэт хамааралтай байдлыг бууруулах зорилгоор хоёр хөршийн эдийн засгийн оролцоог тэнцвэржүүлэх

3. Мал аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах салбарт дотоодын зах зээлд өрсөлдөгч гадаадын компаниудтай өрсөлдөх чадвараа дээшлүүлэхэд нь төрөөс дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх

4. “Гуравдахь” хөрштэй тогтоосон эдийн засгийн хамтын ажиллагааг эрчимтэй хөгжүүлэх зэрэг юм.

Дээрх дөрвөн чиглэлийн аль алинаар үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай байгаа билээ.

Монгол Улсын эдийн засгийн эмзэг байдал нь эдийн засгийн бүтэц, хөгжлийн өнөөгийн түвшинтэй холбоотой бодит шинж чанар давамгайлж байгаа нөхцөлд урсгалаар нь орхивол том гүрнүүдийн түүхий эдийн хавсарга төдий хөгжлийн хэтийн төлөв ажиглагдаж байгаа билээ. Эмзэг байдлыг чиглэсэн зорилго, бодлоготойгоор, хандивлагч улс орны тусламжтай, харьцангуй боловсролтой хүн амын хөдөлмөрийн үр дүнд бууруулах боломжтой юм. Гагцхүү энэ бодлогыг үндэсний түвшинд тавьж, түүхий эдийн экспорт давамгайлсан эдийн засгаас мэдлэг, шинэ техник, технологид суурилсан экспорт давамгайлсан эдийн засагт шилжих замаар орчин үеийн соёл, иргэншлийг эрчимтэй хөгжүүлж хэрэгжүүлж чадна. Энэ чиглэлд “гуравдахь хөрштэй” тогтоосон эдийн засгийн хамтын ажиллагаа чухал үүрэгтэй.

“Гуравдахь хөрш” гэдэг ойлголт нь дэлхийн хоёр их гүрнээр хүрээлүүлсэн Монгол Улсын газар зүйн байрлалын онцлог, түүнээс үүдэн гарч буй улс төр, эдийн засгийн харилцан үйлчлэл, даяарчиллын үед газар зүйн уламжлалт ойлголт тэлж бие биенээсээ алс хол орших улс орнууд ойртон нягтарч хамтран ажиллах боломж нээгдэж буйг тусгасан улс төрийн ойлголт юм. Монголчуудын олон мянган жилийн түүхэнд нүүдэл суудал чухал үүрэгтэй байсан бөгөөд Чингис хааны үед “гуравдахь хөршөө” мориндоо мордон тив алгасан олж байсан бол дараа дараагийн зуунд хоёр хөршөөсөө өөр улс оронтой огт харьцахгүй ертөнцөөс тасархай амьдарч байв. Дэлхийн улс орнуудын харилцаа түгжигдмэл байх үед Монгол нь хойд, урьд хөршөөсөө улс төр, эдийн засгийн хувьд бүрэн хараат байдалд хэдэн зууныг өнгөрүүлсэн билээ. Газар зүйн ба түүхийн хөгжлийн эдгээр онцлог нь монголчуудыг шинэ мянганд “гуравдахь хөршийн” эрэл рүү хөтөлсөн юм. 90-ээд оны эхэн үед социализм нуран унаж, хуучин ЗХУ-ын зээл, тусламж, гадаад худалдаа зогссон тэр үед Япон Улсын санаачилгаар эхэлсэн Монголд хандивлагчдын тусламжийн хөдөлгөөн Монгол Улс орчин үеийн хөгжлийн замд шилжихэд шийдвэрлэх ач холбогдолтой байсан юм. Монгол Улсын “гуравдахь хөрш” “стратегийн түнш” гэдгээ дэлхийн том гүрнүүд, өндөр хөгжилтэй улс орнууд илэрхийлсэн билээ.

“Гуравдахь хөрштэй” тогтоосон хөгжлийн хамтын ажиллагаа

Монгол Улс 1991-2004 онд нийт 2 тэрбум 948 сая ам.долларын хоёр талын ба олон талын хөгжлийн албан ёсны тусламж аваад байна. Үүнээс 1 тэрбум 399 сая ам. доллар нь буцалтгүй тусламж ба 1 тэрбум 549 сая ам.доллар нь хөнгөлөлттэй зээл юм. Монголд буцалтгүй тусламж үзүүлсэн хэмжээгээр нь жагсаавал:

1. Япон
2. АНУ
3. ХБНГУ
4. НҮБ
5. бусад олон талын
6. Европын Холбоо орж байна.

Сүүлийн үед тусламжийг зөвхөн мөнгөний хэмжээгээр харьцуулж ойлгох хандлага нийгмийн сэтгэхүйд ажиглагдах болов. Гэтэл тусламжийн төслүүдийн ач холбогдол Монголын хөгжлийн ирээдүйн чиглэлийг хэр оновчтой тодорхойлж хязгаарлагдмал хүрээнд ч гэлээ нийгэм, эдийн засгийн амьдралд авчирч буй шинэлэг хандлага, ажлын арга барил, стратегийн шинж чанараар тодорхойлогдох учиртай. Жишээлбэл “Гуравдахь хөршөөс” Монголд үзүүлсэн тусламж нь нийгмийн амьдралын бүхий л хүрээг хамарч байсан ба ардчилсан засаглалыг хөгжүүлэх, эдийн засгийн шинэчлэл хийх, Монголын эдийн засгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, нийгмийн, хүмүүнлэгийн, хүний нөөцийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах гэсэн үндсэн чиглэлүүдээр олон зуун төсөл хэрэгжүүлжээ. АНУ, Япон, ХБНГУ, Европын Холбоо, НҮБ-аас Монголд хэрэгжүүлсэн төслүүдийн онцлог гэвэл ядуурлыг бууруулах, эрчим хүчний тогтолцоог бэхжүүлэх зэрэг цаг үеийн асуудлуудад чиглэхээс гадна Монгол Улсын хөгжлийн хэтийн төлөвт эерэгээр нөлөөлөхөд чиглэсэн чадавхи, чадварыг хөгжүүлэх зорилготой байв.

“Гуравдахь хөрш”-ийн хэрэгжүүлсэн төслүүд Монголын эдийн засгийн өрсөлдөх дотоод нөөц бололцоотой тодорхой салбаруудыг анхаарч байгаа нь эдийн засгийн эмзэг байдлыг бууруулахад чухал ач холбогдолтой юм. Тэдгээрээс доорх чиглэлүүд Монголын эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэх, мэдлэг, өндөр хөгжилтэй улс орнуудын шинэ техник, технологийг нэвтрүүлэх боломжийг нээж өгч байна:

Дэлхийн хамтын нийгэмлэг Монгол Улсын хөгжлийн хэтийн төлвийг олон улсын арга, аргачлалын үндсэн дээр тодорхойлох, нийгэм эдийн засгийн гол гол асуудлуудыг судлахад чухал туслалцаа үзүүлж байна. Жишээлбэл НҮБХХ-өөс эдийн засгийн хөгжлийг хүний хөгжилтэй уялдуулах орчин үеийн аргачлалыг нэвтрүүлэх зорилгоор 1997 оноос хойш жил бүр Монголын Хүний Хөгжлийн илтгэлийг гаргаж, Монголын засгийн газрын хүсэлтээр 2005 онд “Эдийн засгийн ба Байгаль Орчны эмзэг байдал ба Хүний аюулгүй байдлын” талаарх илтгэл, 2006 онд “Монголын аж үйлдвэрийн салбарын өрсөлдөх чадварын Үнэлгээ” илтгэлүүд нь эдийн засгийн эмзэг байдлыг бууруулахад чиглэсэн стратегийн чиглэлүүдийг тодорхойлоход чухал ач холбогдолтой болсон юм.

Европын Холбоо нь Монголын хөдөөг тусламжийн тэргүүлэх чиглэлээ болгосон нь онцгой ач холбогдолтой юм. Монголын экспортын үйлдвэрлэлийн үндэс суурь болсон мал аж ахуй, газар тариалангийн салбарын ДНБ-д эзлэх хувь хэмжээ 1995 онд 38% байсан бол 2005 онд 21.7% болж буурчээ. Үр тарианы үйлдвэрлэл 2002-2005 онд 40.3 хувиар буурсан бол хүн амын гурилын хэрэгцээ өссөөр байна. 2005 оны байдлаар гурилын жилийн нийт хэрэгцээнийхээ дөнгөж 22.2%-ийг дотооддоо үйлдвэрлэсэн ба нийт хэрэгцээнийхээ 37.6%-ийг импортоор оруулжээ.⁹ Харин үлдсэн 40.2%-ийг гадаадын тусламжаар /АНУ, Франц, Итали ба олон улсын хүмүүнлэгийн байгууллагуудын тусламжаар/ авчээ.

Европын Холбоо нь үр тариа, мал аж ахуйн салбарыг дээшлүүлэх, фермерийн хувийн аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар хүн амын хүнсний аюулгүй байдлыг урт хугацаанд баталгаатай болгох зорилго тавьж төсөл хэрэгжүүлж байна.

2003 онд Монгол Улс, ЕХ-ны хамтын ажиллагааны хамтарсан хорооны VII хуралдаанаар “Мах, малын гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр Европын Холбоотой хамтран ажиллах боломж” сэдэвт илтгэл хэлэлцүүлж, “Мах судлалын лаборатори байгуулах”, “Малын эмийн үлдэгдлийг хянан шалгах лабораторийг бэхжүүлэх” төслүүдийг 2004 оноос хэрэгжүүлж эхлээд байна. Түүнчилэн Дорноговь, Говь Сүмбэр, Сүхбаатар аймгуудад мал эмнэлгийн үйлчилгээ, малын тэжээлийн үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн боловсруулах үйлдвэрлэл хөгжүүлэх, бэлчээр нутгийг тогтвортой сайжруулах чиглэлээр ажиллажээ.

Европын Холбоо 2004-2006 онд 9 сая еврогийн тусламж үзүүлж Монголын хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспортын боломжийг нэмэгдүүлэх, хөдөөд ядуурлыг бууруулахад зориулж зээл олгожээ.

Ийнхүү Европын Холбоо нь мал аж ахуйн гаралтай үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд шийдвэрлэх ач холбогдолтой салбарууд болох мал эмнэлэг, үр тарианы үйлдвэрлэл, мал аж ахуйн бүтээгдэхүүний чанарыг сайжруулахад анхаарч байгаа нь хэдийгээр хязгаарлагдмал тооны аж ахуй, байгууллагыг хамарч байгаа боловч улсын хэмжээнд үлгэр болж болох европ стандарт, технологийг нэвтрүүлэх туршилт хийж байгаагаараа Монголын хувьд чухал ач холбогдолтой энэ салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, улмаар алс хэтдээ эдийн засгийн эмзэг байдлыг бууруулахад чухал ач холбогдолтой хамтын ажиллагаа болж байгаа юм.

Европын Холбооноос 7200 нэр төрлийн бүтээгдэхүүнийг гаалийн татваргүй, тоо, хэмжээний хязгаарлалтгүй нэвтрүүлэх боломж олгосныг бүрэн дүүрэн ашиглах явдал маш чухал юм. Харин үүний

тулд мал аж ахуйн гаралтай түүхий эдийн боловсруулах үйлдвэрлэлийг сэргээж хөгжүүлэх, үүний тулд хөгжилтэй улс орны тэргүүний техник, технологийг нэвтрүүлэх ажил урьдчилсан бэлтгэл ажил болох учиртай. Чухам эл зорилгод Европын Холбооноос хөдөө аж ахуйн чиглэлээр хэрэгжүүлсэн, одоо хэрэгжүүлж байгаа төслүүд тус дэм болох юм.

Монгол Улсаас “гуравдахь хөршийн” орнуудтай доорхи чиглэлээр тогтоосон хамтын ажиллагаа, тухайлбал:

- **сэргээгдэх эрчим хүчний салбарт** ХБНГУ-ын буцалтгүй тусламжийн 50% нь зориулагдаж байгаа, Исландын хөрөнгө оруулагчидтай Монголд газрын гүний эрчим хүчийг ашиглах талаар судалгаа хийхээр тохиролцсон,

- **геологи, геофизикийн судалгааны чиглэлд** Франц Улстай хамтарч сансраас тандан судлах системийг Монголд нэвтрүүлэн геологийн автоматжуулсан мэдээллийн сан байгуулах, 1995 онд чичирхийллийн “Альфа” станцыг ашиглалтанд оруулсан, 2005 онд Бельги Улс Монголын газрын тосны нөөцийг тогтоох, металлын бирж байгуулах Монголын саналыг анхааралтай судлахаар болсон,

- **мал аж ахуйн салбарт** Словак Улс мал хээлтүүлгийн биотехнологийн шинэ аргачлалыг нэвтрүүлэх,

- **арьс шир боловсруулах, гутлын үйлдвэрлэлд** зориулж Чех Улс буцалтгүй тусламж үзүүлж байгаа,

- **мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн чиглэлд** Шведийн тусламжтай хот, хөдөөд 58 нэгжийг шинэчилж зориулалтын тоног, төхөөрөмж суурилуулах ажил хийгдэнэ.

- **Боловсролын салбарт** үзүүлж буй тусламжийн хүрээнд Японд 800 оюутан, Австри, Бельги, Польш, Чех, Румынд нийт 100 гаруй оюутан, аспирант суралцаж байгаа зэрэг нь

Монголын эдийн засгийн эрчимтэй хөгжилд хувь нэмэр болж улмаар эдийн засгийн эмзэг байдлыг бууруулахад чухал ач холбогдолтой болж байна.

“Гуравдахь хөрштэй” тогтоосон худалдаа, хөрөнгө оруулалтын харилцаа

Дундаж %-иар

Бүс нутаг	Худалдаа – 1995-2005	Хөрөнгө оруулалт 1990-2004
Хоёр хөрш	51%	42.9% (БНХАУ-39.6%, ОХУ-3.3%)

“гуравдахь хөрш”-Хойд Америк, Европын	22.9%		28.4%
“гуравдахь хөрш” –Зүүн Хойд, Зүүн Өмнөд Азийн	12.4% БНСУ	(Япон,	20.5% (Япон, БНСУ)

Эх сурвалж: Монгол Улсын гадаад бодлогын хөх ном 2006, х. 72, 76-д байгаа тоо баримтыг харьцуулан тооцоолов.

Энэ хүснэгтнээс харахад Монгол Улсын гадаад худалдаа, хөрөнгө оруулалтад Европ, Америк, Азийн “гуравдахь хөршийн” оролцоо бас ч чамлахааргүй байгаа бөгөөд аль алиныг нь нэмэгдүүлснээр Монголын эдийн засаг түүхий эдийн экспорт давамгайлсан өнөөдрийн түвшнээс техник, технологид суурилсан чанарын шинэ шатанд гарахад чухал ач холбогдолтой юм.

Монголын гадаад худалдаанд АНУ, Европын Холбоо нь стратегийн чухал түнш болж байна. Өнөөдөр Монголын экспортын чухал бүтээгдэхүүн болох оёмол, сүлжмэл эдлэлийг АНУ, ХБНГУ, Канад, Франц руу, самнасан ноолуур, ноолууран эдлэлийг Их Британи, Япон, Итали руу, Нидерланд руу ноолуур, өлөн гэдэс, тэмээний ноос, адууны дэл сүүл, Швед руу ангийн хөлдөөсөн мах, ноос, ноолууран эдлэл, хивс экспортлох тухай ярьж байгаа. Финланд руу савхи, зэсийн баяжмал гаргаж байна.

АНУ, Европын Холбоо худалдааны тааламжтай нөхцөл олгож буйг бүрэн дүүрэн ашиглахын тулд салбарын яамдын уялдаа холбоог сайжруулах замаар гадаад худалдааг хүнс, хөдөө аж ахуйн бодлоготой нягт зангидсан хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хөрөнгө оруулалтын салбарт анхаарах ёстой асуудлууд гэвэл нэгд, эрдэс түүхий эд боловсруулах салбарыг хөгжүүлэх, хоёрт, олон улсын том корпорациуд нь шинэ техник, инновацийг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдгийг анхааран ажиллах хэрэгтэй байна. Тиймээс гадаадын хөрөнгө оруулалтын шалгуурыг өндөрсгөж, шинэ технологийг нэвтрүүлж буй байдал, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд оруулж буй хувь нэмэрт нь үнэлгээ өгөх шаардлагатай болжээ. Хөгжлийн Албан ёсны тусламжийн Байгууллагаас (OECD) “Үндэстэн дамнасан Корпорациудын үйл ажиллагааны талаарх Удирдамж”-д /Шинжлэх ухаан ба Технологи гэсэн 7-р бүлэгт/ “корпорациуд нь үйл ажиллагаагаа тухайн орны шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөгөөтэй уялдууах ба орон нутгийн ба үндэснийх нь инновацийн

үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулна”¹⁰ гэж заасан байдаг. Монголд уул уурхайн чиглэлээр дэлхийд томоохонд ордог компаниуд хөрөнгө оруулалт хийн ажиллаж байгаа бөгөөд энэ чиглэлийн олон улсын хууль эрх зүйн мэдлэг, мэдээлэл хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлэх, хандивлагч байгууллага, улс орнуудтай харилцахад чухал болж байна.

Ашигласан материал

1. Economic and Ecological Vulnerabilities and Human Security in Mongolia, Ulaanbaatar, 2005,
2. *ibid.*, p. 28
3. Б.Ганзориг, Д.Начин. Монгол Улс дахь Орос, Хятадын хөрөнгө оруулалтын тухай. “Олон Улс судлал”, 2006, №3, х.7
4. мөн тэнд, х. 9
5. Common Country Assessment 2004, Balancing Development to Achieve an All-Round Xiaokang and Harmonious Society in China, UN Country Team in China, p.21
6. UN Industrial Development Organization, Mongolia: Competitiveness Assessment of the Industrial Sector, Final report, Vienna, January 2006, p. viii
7. Монгол Улсын эдийн засгийн 2005 оны тойм, 2006 оны төлөв байдал, МҮХАХТ, УБ, 2006, х. 59
8. UN Industrial Development Organization, Mongolia: Competitiveness Assessment of the Industrial Sector, Final report, Vienna, January 2006, p. 24
9. Монгол Улсын эдийн засгийн 2005 оны тойм, 2006 оны төлөв байдал, МҮХАХТ, УБ, 2006, х. 36
10. World Investment Report, 2005, Transnational Corporations and the Internationalization of R&D, p. 232